



## ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал  
бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663

Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням  
Утас: 261885

Аудитор Б.Долгоржав  
Утас: 260512

Юнистар аудит ХХК-ийн  
Аудитор Б.Тэрбиш  
Утас: 328735  
Цахим хаяг: [unistar\\_audit@yahoo.com](mailto:unistar_audit@yahoo.com)

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар  
хороо Мигма төв байр 306 тоот

2018 оны 2 дугаар сар

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн  
тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайлан



## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

**Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ/2018/153/СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.


Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-наас 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хугацаанд хийхээр төлөвлөн Юнистар Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш ахлагчтай баг хэрэгжүүлж ажиллав. /ТАБ-СТА-А-8/

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн санхүүгийн тайлангийн аудитын явцад зарим залруулга хийх шаардлагатай болсон тул аудитын зөвлөмжийн дагуу залруулга хийж, санхүүгийн тайланг дахин гаргаж 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 19-нд Юнистар Аудит ХХК-д ирүүлсэн.

Юнистар Аудит ХХК нь аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-наас 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн удирдлагад гардуулна.

**Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эрүүл мэндийн тухай, Донорын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон эдгээртэй нийцүүлэн



гаргасан Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын холбогдох тушаалууд бусад эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

### **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиг үүргийг улсын хэмжээнд донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн төрөлжсөн мэргэжлийн дүгнэлт гаргах, донор, цус цусан бүтээгдэхүүний тусламж, эмчилгээний заавар, стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэгтэй эрүүл мэндийн байгууллага гэж тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангах ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус байгууллагын 2017 оны төсвийг Эрүүл мэндийн яамны төрийн сангаас олгож байна. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан

### **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 15 горим гүйцэтгэв. /ТАБ-СТА-5-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 дугаар тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажилгаанд тохируулан мөрдөж байна. Тус газар нь Санхүүгийн тооцооллын Aculous-3.0 санхүүгийн програмыг хэрэглэж байгаад, Цус цусан бүтээгдэхүүний өртөг тооцоох төрийн интерактив Ай Би компанийн Emerald, цалингийн тооцооны Раугол системийг 2017 оны 9 дүгээр сараас нэвтрүүлэн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлээ хөгжүүлж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Emerald” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу тайлангаа бэлтгэсэн байна.

### **Тав. Материаллаг байдал:**

Бид санхүүгийн тайланд материаллаг байдлыг авч үзэхдээ орлогын хэмжээ байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлно гэж үзэж санхүүгийн тайлангийн материаллаг түвшинг орлогын 1 хувиар буюу алдааг хүлээн зөвшөөрөх нийт хэмжээг 49,136.4 мянган төгрөгөөр тооцоолов. /ТАБ-СТА-В-1/

### **Зургаа. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байлаа.

### **Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**


Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Эрүүл мэндийн яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны орлогыг 4,908,500.0 мянган төгрөгөөр, үүнээс улсын төсвийн санхүүжилтээр 3,458,940.0 мянган төгрөг, өөрийн орлогоор 1,449,560.0 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,460,986.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,452,653.0 мянган төгрөгийн өөрийн орлого, 30,779.2 мянган төгрөгийн хандивын орлого олж, нийт 4,913,638.9 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, 4,822,189.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Найм. Шилэн дансны мэдээлэл**

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу ажилласан байна. Үүнд:

1. 2017 оны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан баланс,
2. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан,
3. 2017 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол,
4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хугацаа хоцроож 3,698,402.0 мянган төгрөгийн, гүйцэтгэлийн тайлан 3,709,402.0 мянган төгрөгөөр 12 удаа, 5.0 саяаас дээш худалдан авалт /Гендерийн худалдан авалт/-ын тухай 12 удаа, гэрээний үнийн дүн 3,794,771.13 мянган төгрөг, худалдан авалтын санхүүжилт 3,810,385.08 мянган төгрөгөөр,
5. Байгууллагын батлагдсан орон тоонд оруулсан өөрчлөлтийг 12 удаа мэдээлсэн,



6. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгслүүдийн хураамж үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтүүдийг тухай бүр оруулсан,
7. Батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарыг сар улирлаар оруулсан. Батлагдсан төсөв 4,908,500.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 4,913,638.9 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, 4,822,189.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, 15 сорил гүйцэтгэв.

**Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, төсвийн санхүүжилт, үйл ажиллагааны зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн, нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь 2016 оны жилийн санхүүгийн тайлан гаргахдаа бараа материалын эцсийн үлдэгдлийг тооллогын дүнгээр буюу 2016 оны 12 сарын 15-ны өдрөөр тасалбар болгосноос 346,060.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсан.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь Монгол Улсын хэмжээнд донор, цус цусан бүтээгдэхүүний тусламж үзүүлдэг онцгой байгууллага учраас үйл ажиллагаа тасралтгүй явагдаж, борлуулалтын урсгал авлага тогтмол үүсдэг онцлогтой.

**Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь 2016 оны жилийн санхүүгийн тайлан гаргахдаа бараа материалын эцсийн үлдэгдлийг тооллогын дүнгээр буюу 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгосноос 346,060.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн дээрхи алдааг аудитын явцад залруулав.



2. Аудитын горимын дагуу харилцагч байгууллагуудтай тулган баталгаажуулалт хийхэд Моном фарм трейд ХХК-иас авах авлага 1,275.0 мянган төгрөгөөр, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгээс авах авлага 336.7 мянган төгрөгөөр илүү, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс авах авлага 96.0 мянган төгрөгөөр дутуу байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрхи авлагаас 1,611.7 мянган төгрөгийн авлагыг аудитын явцад залруулав. Илүү дүнгээр бүртгэсэн 96.0 мянган төгрөгийн авлагыг тодруулж, 2018 онд залруулах зөвлөмж өгөх.

3. Дуу өсгөгч, хөшиг, гантел гэх мэт 36,564.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн. Хөрөнгийг стандартын дагуу зөв ангилж бүртгээгүй, байгууллагын онцлогт тохирсон НБББББ-гүй байна.

Шийдвэрлэсэн: Салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн бодлогын баримт бичиг боловсруулах талаар зөвлөмж өгөх.

### **Арван хоёр. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс авах авлага 96.0 мянган төгрөгөөр дутуу баталгаажсан зөрчлийг 2017 оны санхүүгийн тайланд залруулаагүй болно.

### **Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц материаллаг хэмжээний бусад чухал асуудал байхгүй.

### **Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал болон үйлдвэрлэлийн технологийн нарийн төвөгтэй байдлаас тус тус шалтгаалан дуусаагүй үйлдвэрлэлийн дансыг нарийвчлан шалгаж чадаагүй болно.

### **Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 384,332.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 384,236.3 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 96.0 мянган төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгөв.

### **Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2016 оны санхүүгийн тайланд 2 зөвлөмж өгсөн ба авлага өглөггүй ажиллах зөвлөмж хэрэгжээгүй байна. Энэ нь тус төв улсын хэмжээнд цусны донорын үйлдвэрлэл, тусламж үйлчилгээ үзүүлдэг цорын ганц байгууллага учраас 24 цагаар үйлдвэрлэл, тусламж үйлчилгээ тасралтгүй явагддаг. Нөгөө талаас худалдан авагчид нь төсвийн байгууллагууд тул төсвийн санхүүжилтээс шалтгаалж эргэлтийн авлага байнга үүсдэг онцлогтой байдлаас шалтгаалан урьд оны аудитын зөвлөмж хэрэгжихгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.



### **Арван долоо. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**

#### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө



өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

## АУДИТЫН ТАЙЛАНГ

### БЭЛТГЭСЭН:

Юнистар аудит ХХК-ийн аудитор  
Чанарын хяналтын менежер

/Б. Тэрбиш/  
/Т. Энхтуяа/





**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**Тэргүүлэх ач холбогдол № 1**

**Асуудал 1**

**Авлага**

**Тэргүүлэх ач холбогдол № 2**

**Асуудал 2**

**Үндсэн хөрөнгийн ангилал, бүртгэлийн**

**бодлогын талаар**



## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитийн газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хяналт хийсэн бөгөөд оршин буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс бидний зөвлөмж дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан захирал, ерөнхий нягтлан бодогч болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.



**Асуудал 1: Авлага**

**Тэргүүлэх ач  
холбогдол №1**

Ажиглалт

Аудитын горимын дагуу харилцагч байгууллагуудтай тулган баталгаажуулалт хийхэд Монос фарм трейд ХХК-иас авах авлага 1,275.0 мянган төгрөгөөр, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгээс авах авлага 336.7 мянган төгрөгөөр илүү, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс авах авлага 96.0 мянган төгрөгөөр дутуу байна.

Зөвлөмж

Дээрхи авлагаас 1,611.7 мянган төгрөгийн авлагыг аудитын явцад залруулав. Илүү дүнгээр бүртгэсэн 96.0 мянган төгрөгийн авлагыг тодруулж, 2018 онд залруулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хүргүүлэх.

Эрсдэл

Авлагыг зөрүүтэй бүртгэж тайлагнаснаар төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэл үүсэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.



**Асуудал 2: Үндсэн хөрөнгийн ангилал ба  
НБББББ**

**Тэргүүлэх ач  
холбогдол №2**

Ажиглалт

Дуу өсгөгч, хөшиг, гантел гэх мэт 36,564.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн. Хөрөнгийг стандартын дагуу зөв ангилж бүртгээгүй, байгууллагын онцлогт тохирсон НБББББ-гүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

Зөвлөмж

Салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөх, хөрөнгийг зөв ангилж бүртгэх,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хүргүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.



**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,063,691,340.00</b>	<b>4,095,016,298.86</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>10,100.00</b>	<b>210,880.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө ТӨААН	10,100.00	210,880.00
<b>АВЛАГА</b>	<b>42,029,659.00</b>	<b>56,459,189.54</b>
Байгууллагаас авах авлага	42,029,659.00	56,459,189.54
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>27,786,092.00</b>	<b>126,308,260.00</b>
Урьдчилж гарсан зардал	27,592,000.00	126,308,260.00
Цалингийн урьдчилгаа	194,092.00	
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,993,041,729.00</b>	<b>3,850,271,857.43</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>3,993,041,729.00</b>	<b>3,376,402,767.07</b>
Тусгай зориулалттай материал	234,132,190.00	412,065,896.40
Эм боох материал	3,758,909,539.00	2,964,336,870.67
Бэлэн бүтээгдэхүүн		473,869,090.36
<b>Хангамжийн материал</b>	<b>823,760.00</b>	<b>61,766,111.89</b>
Бичиг хэргийн материал	823,760.00	6,026,340.00
Аж ахуйн материал		23,037,267.80
Сэлбэг хэрэгсэл		4,620.00
Түлш, шатах тослох материал		1,483,556.00
Барилгын засварын материал		78,000.00
Хүнсний материал		16,735,828.09
Бусад хангамжийн материал		14,400,500.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,357,281,056.30</b>	<b>9,445,821,161.77</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>9,357,281,056.30</b>	<b>9,445,821,161.77</b>
Барилга, байгууламж, орон сууц	3,811,953,373.30	3,861,953,373.30
Хуримтлагдсан элэгдэл	(275,358,852.00)	(334,220,526.22)
Авто-тээврийн хэрэгсэл	94,507,000.00	94,507,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(63,135,119.00)	(74,294,902.75)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,964,472,253.00	7,397,670,430.50
Хуримтлагдсан элэгдэл	(1,608,907,639.00)	(2,175,630,848.68)
Тавилга, аж ахуйн эд хогшил	453,133,125.00	708,940,119.40
Хуримтлагдсан элэгдэл	(92,469,353.00)	(111,460,077.99)
Бусад үндсэн хөрөнгө	5,043,300.00	5,043,300.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,043,300.00)	(5,043,300.00)
Програм хангамж	75,008,305.00	80,392,055.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,922,037.00)	(2,035,460.79)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>13,420,972,396.30</b>	<b>13,540,837,460.63</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,654,380.00</b>	<b>3,735,000.00</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,654,380.00</b>	<b>3,735,000.00</b>
<b>Өглөг</b>	<b>2,654,380.00</b>	<b>3,735,000.00</b>
Байгууллагад төлөх өглөг	2,654,380.00	
Хувь хүмүүст төлөх өглөг		3,735,000.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>13,418,318,016.30</b>	<b>13,537,102,460.63</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,751,097,413.00	2,751,097,413.00

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хуримтлагдсан үр дүн	10,451,782,225.30	10,570,566,669.63
Өмнөх үеийн үр дүн	(418,963,777.31)	10,798,617,609.58
Тайлант үеийн үр дүн	10,870,746,002.61	(228,050,939.95)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	215,438,378.00	215,438,378.00
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>13,420,972,396.30</b>	<b>13,540,837,460.63</b>



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>15,650,353,999.00</b>	<b>5,770,134,393.04</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО</b>	<b>1,169,636,098.00</b>	<b>1,470,721,678.36</b>
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,169,636,098.00</b>	<b>1,470,721,678.36</b>
Үйл ажиллагааны орлого	1,169,636,098.00	1,366,751,654.30
Туслах үйл ажиллагааны орлого		103,970,024.06
<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>7,864,586,809.00</b>	<b>879,591,031.90</b>
Хандив тусламж-Дотоод	2,715,770,875.00	600,704,650.00
Хандив-Гадаад	5,148,815,934.00	278,886,381.90
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,616,131,092.00</b>	<b>3,419,821,682.78</b>
<b>Тусламж санхүүжилтийн орлого</b>	<b>6,616,131,092.00</b>	<b>3,419,821,682.78</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,407,451,900.00	3,460,986,000.00
Улсын төсөвт татан төвлөрүүлсэн	(159,995,368.00)	(121,943,543.22)
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		22,929,704.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,368,674,560.00	53,797,522.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,052,000.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,779,607,996.69</b>	<b>5,998,185,332.99</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,779,607,996.69</b>	<b>5,998,185,332.99</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,749,320,476.69</b>	<b>5,947,706,632.99</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>605,281,880.00</b>	<b>147,281,164.00</b>
Үндсэн цалин	605,281,880.00	110,348,400.00
Унаа хоолны хөнгөлөлт		44,784,000.00
Урамшуулал	3,150,000.00	22,148,764.00
<b>Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>72,218,147.00</b>	<b>17,673,739.68</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,388,746.00</b>	<b>25,917,893.86</b>



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Гэрэл цахилгаан	29,376,628.00	15,770,401.00
Түлш, халаалт	21,137,068.00	4,326,650.58
Цэвэр, бохир ус	12,875,050.00	5,820,842.28
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,531,671.00</b>	<b>4,272,632.82</b>
Бичиг хэрэг	2,275,377.00	28,100.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,202,934.00	1,505,032.82
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,439,567.00	2,580,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,613,793.00	159,500.00
<b>Нормативт зардал</b>	<b>3,569,146,225.69</b>	<b>5,567,863,510.20</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,479,462,951.69	5,566,834,210.20
Хоол, Хүнс	88,188,274.00	1,029,300.00
Зөөлөн эд нормын хувцас авах зардал	1,495,000.00	
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,525,923.00</b>	<b>18,112,422.00</b>
Багаж, техник хэрэгсэл	506,000.00	750,000.00
Тавилга	1,055,000.00	
Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	1,280,000.00	
Урсгал засвар	5,684,923.00	17,362,422.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,638,000.00</b>	<b>1,164,700.00</b>
Дотоод албан томилолт	1,638,000.00	1,164,700.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,955,830.00</b>	<b>35,760,006.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,920,330.00	27,356,580.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	2,200,000.00
Даатгалын үйлчилгээ	350,000.00	840,300.00
Тээврийн хэрэгслийн татвар	180,600.00	181,200.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000.00	10,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,977,900.00	4,854,926.00
Газрын төлбөр	247,000.00	247,500.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	63,500.00

01  
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>37,034,923.00</b>	<b>16,767,974.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	36,937,344.00	16,767,974.00
Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	97,579.00	-
<b>Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал</b>	<b>335,599,131.00</b>	<b>112,892,590.43</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,287,520.00</b>	<b>50,478,700.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,287,520.00	31,918,700.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18,560,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>10,870,746,002.31</b>	<b>(228,050,939.95)</b>



**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Аудитлагдсан
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,739,970,965.00</b>	<b>4,944,418,224.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,308,235,915.00</b>	<b>1,452,652,998.00</b>
Нийтлэг татварын бус орлого	-	1,452,652,998.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1452,652,998.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,308,235,915.00	1,322,652,998.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	130,000,000.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,431,735,050.00</b>	<b>3,491,765,226.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,407,451,900.00</b>	<b>3,460,986,000.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>30,779,226.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	3,460,986,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,915,350.00	22,929,704.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,797,522.00
Төсвийн болон байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,367,800.00	4,052,000.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>4,735,818,765.00</b>	<b>4,944,123,144.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,545,535,877.00</b>	<b>4,933,469,394.00</b>
<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,545,535,877.00</b>	<b>4,761,057,250.78</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>604,123,312.00</b>	<b>652,115,500.00</b>
Үндсэн цалин	473,376,342.00	462,004,636.30
Нэмэгдэл		46,852,300.00
Унаа Хоолны хөнгөлөлт	52,845,866.00	59,611,900.00
Урамшуулал	77,901,104.00	83,611,900.00
<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,172,907.00</b>	<b>77,582,200.00</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	72,172,907.00	77,582,200.00
<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,388,746.00</b>	<b>110,031,120.96</b>
Гэрэл цахилгааны зардал	29,376,628.00	72,952,205.00
Түлш, халаалтын зардал	21,137,068.00	24,434,911.00
Цэвэр, бохир усны зардал	12,875,050.00	12,654,004.96
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,387,227.00</b>	<b>31,341,612.82</b>
Бичиг хэрэг	1,459,800.00	1,586,200.00
Тээвэр, шатахуун	5,550,900.00	7,128,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,439,567.00	1,505,032.82
Хог хаягдал зайлуулах, хортон марэгчдийн устгал, ариутгал	10,629,960.00	20,842,880.00

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	307,000.00	279,500.00
<b>Нормативт зардал</b>	<b>3,704,850,051.00</b>	<b>3,767,098,300.00</b>
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,600,428,000.00	3,670,362,500.00
Хоол, хүнс	102,927,051.00	93,965,800.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,495,000.00	2,770,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,903,713.00</b>	<b>29,524,782.00</b>
Багаж техник хэрэгсэл	1,307,290.00	3,712,150.00
Хөдөлмөр хамгаалалын хэрэглэл	1,450,000.00	1,336,500.00
Урсгал засвар	9,46,423.00	24,476,222.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,638,000.00</b>	<b>1,164,700.00</b>
Дотоод албан томилолт	1,638,000.00	1,164,700.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,944,900.00</b>	<b>46,227,970.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	17,909,400.00	27,356,580.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	2,200,000.00
Даатгалын үйлчилгээ	350,000.00	846,300.00
Тээврийн хэрэгслийн татвар	180,600.00	209,200.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	10,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,977,900.00	4,854,926.00
Газрын төлбөр	247,000.00	247,500.00
Улсын мэдээлэлийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	10,503,464.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,127,021.00</b>	<b>45,970,975.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	44,127,021.00	45,970,975.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>159,995,368.00</b>	<b>172,412,143.22</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>121,933,443.22</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	121,933,443.22
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	159,995,368.00	<b>50,478,700.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,287,520.00	31,918,700.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		18,560,000.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,142,100.00</b>	<b>10,653,750.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<b>4,142,100.00</b>	<b>10,653,750.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>295,080.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,100.00	<b>305,180.00</b>



**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	(419,965,111.01)	2,546,570,679.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,001,334.00	1,001,334.00
Тайлант үеийн үр дүн	-	-	10,870,746,002.31	10,870,746,002.31
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	10,451,782,225.30	13,418,318,016.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	346,835,384.28	346,835,384.28
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	10,798,617,609.58	13,765,153,400.58
Тайлант үеийн үр дүн	-	-	(228,050,939.95)	(228,050,939.95)
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	10,570,566,669.63	13,537,102,460.63

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**


**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн /төгрөгөөр/
<b>(I) ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,739,970,965.00</b>	<b>4,944,418,224.00</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО</b>	<b>1,308,235,915.00</b>	<b>1,452,652,998.00</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,308,235,915.00	1,452,652,998.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,308,235,915.00	1,452,652,998.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,308,235,915.00	1,322,652,998.00
Туслах үйл ажиллагааны орлогоос	0.00	130,000,000.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,431,735,050.00</b>	<b>3,491,765,226.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,407,451,900.00</b>	<b>3,460,986,000.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,407,451,900.00	3,460,986,000.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>24,283,150.00</b>	<b>30,779,226.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,094,850.00	22,929,704.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,247,800.00	3,797,522.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,940,500.00	4,052,000.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,739,960,865.00</b>	<b>4,944,217,444.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,735,818,765.00</b>	<b>4,927,499,944.00</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,545,535,877.00</b>	<b>4,755,077,700.78</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>604,123,312.00</b>	<b>652,115,500.00</b>
Үндсэн цалин	473,376,342.00	462,004,636.30
Нэмэгдэл	0.00	46,852,300.00
Унаа хоолны Хөнгөлөлт	52,845,866.00	59,611,900.00
Урамшуулал	77,901,104.00	83,646,663.70
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,172,907.00</b>	<b>77,582,200.00</b>
Тэтгэврийн даатгал	72,172,907.00	77,582,200.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,388,746.00</b>	<b>110,031,120.96</b>
Гэрэл, цахилгаан	0.00	0.00
Түлш, халаалт	21,133,889.00	24,911.00
Цэвэр, бохир ус	1,881,000.00	1,004.96
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,387,227.00</b>	<b>31,341,612.82</b>
Бичиг хэрэг	1,459,800.00	1,586,200.00
Тээвэр, шатахуун	5,550,900.00	7,128,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,439,567.00	1,505,032.82
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,629,960.00	20,842,880.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	307,000.00	279,500.00

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

<b>Нормативт зардал</b>	<b>3,704,850,051.00</b>	<b>3,767,182,500.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,600,428,000.00	3,670,446,700.00
Хоол, хүнс	102,927,051.00	93,965,800.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,495,000.00	2,770,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,903,713.00</b>	<b>29,524,872.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	3,052,190.00	3,712,150.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,450,000.00	1,336,500.00
Урсгал засвар	7,401,523.00	24,476,222.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,638,000.00</b>	<b>1,164,700.00</b>
Дотоод албан томилолт	1,638,000.00	1,164,700.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,944,900.00</b>	<b>46,227,970.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,909,400.00	27,356,580.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	2,200,000.00
Даатгалын үйлчилгээ	350,000.00	846,300.00
Тээврийн хэрэгслийн татвар	180,600.00	209,200.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	10,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,977,900.00	4,854,926.00
Газрын төлбөр	247,000.00	247,500.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	10,503,464.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,127,021.00</b>	<b>39,907,225.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	44,127,021.00	39,907,225.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>190,282,888.00</b>	<b>172,422,243.22</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>159,995,368.00</b>	<b>121,943,543.22</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	159,995,368.00	121,943,543.22
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,287,520.00</b>	<b>50,478,700.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,287,520.00	31,918,700.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	18,560,000.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,142,100.00</b>	<b>16,717,500.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал	4,142,100.00	16,717,500.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>10,100.00</b>	<b>200,780.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>10,100.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>10,100.00</b>



**АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛ</b>				
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,910,861,805.00</b>	<b>4,791,974,678.78</b>	<b>-118,887,126.22</b>	<b>97.58</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,856,648,105.00</b>	<b>4,741,495,978.78</b>	<b>-115,152,126.22</b>	<b>97.63</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>646,519,000.00</b>	<b>646,519,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Үндсэн цалин	452,221,800.00	462,004,636.30	9,782,836.30	102.16
Нэмэгдэл цалин	46,852,300.00	46,852,300.00	0.00	100.00
Унаа хоолны Хөнгөлөлт	59,611,900.00	59,611,900.00	0.00	100.00
Урамшуулал	87,833,000.00	78,050,163.70	-9,782,836.30	88.86
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,582,200.00	77,582,200.00	0.00	100.00
<b>Тэтгэврийн даатгал</b>	<b>77,582,200.00</b>	<b>77,582,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,639,200.00	110,031,120.96	-111,608,079.04	49.64
Гэрэл, цахилгаан	144,195,000.00	72,952,205.00	-71,242,795.00	50.59
Түлш, халаалт	39,180,700.00	24,424,911.00	-14,755,789.00	62.34
<b>Цэвэр, бохир ус</b>	<b>38,263,500.00</b>	<b>12,654,004.96</b>	<b>-25,609,495.04</b>	<b>33.07</b>
Хангамж, бараа материалын зардал	32,768,600.00	31,341,612.82	-1,426,987.18	95.65
Бичиг хэрэг	1,586,200.00	1,586,200.00	0.00	100.00
Тээвэр, шатахуун	7,128,000.00	7,128,000.00	0.00	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,890,300.00	1,505,032.82	-385,267.18	79.62
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,802,900.00	20,842,880.00	-960,020.00	95.60
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	361,200.00	279,500.00	-81,700.00	77.38
Нормативт зардал	3,756,864,500.00	3,756,862,500.00	-2,000.00	100.00
<b>Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл</b>	<b>3,660,042,500.00</b>	<b>3,660,126,700.00</b>	<b>84,200.00</b>	<b>100.00</b>
Хоол, хүнс	94,050,000.00	93,965,800.00	-84,200.00	99.91
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,772,000.00	2,770,000.00	-2,000.00	99.93
Эд хогшил, урсгал засварын зардал	27,432,500.00	27,432,150.00	-350.00	100.00
<b>Багаж, техник, хэрэгсэл</b>	<b>3,712,500.00</b>	<b>3,712,150.00</b>	<b>-350.00</b>	<b>99.99</b>
<b>Хөдөлмөр хамгааллын хэрэглэл</b>	<b>1,336,500.00</b>	<b>1,336,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Урсгал засвар	22,383,500.00	22,383,500.00	0.00	100.00
Томилолт, зочны зардал	1,164,700.00	1,164,700.00	0.00	100.00
Дотоод албан томилолт	1,164,700.00	1,164,700.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,342,680.00	46,227,970.00	-2,114,710.00	95.63
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,356,580.00	27,356,580.00	0.00	100.00



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,475,000.00	2,200,000.00	-275,000.00	88.89
Даатгалын үйлчилгээ	851,400.00	846,300.00	-5,100.00	99.40
<b>Тээврийн хэрэгслийн татвар</b>	<b>396,000.00</b>	<b>209,200.00</b>	<b>-186,800.00</b>	<b>52.83</b>
Тээврийн хэрэгслийн оношилгоо	89,100.00	10,000.00	-79,100.00	11.22
<b>Мэдээлэл, технологийн үйлчилгээ</b>	<b>6,037,100.00</b>	<b>4,854,926.00</b>	<b>-1,182,174.00</b>	<b>80.42</b>
<b>Газрын төлбөр</b>	<b>247,500.00</b>	<b>247,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,890,000.00	10,503,464.00	-386,536.00	96.45
Бараа үйлчилгээний бусад зардал	44,334,725.00	44,334,725.00	0.00	100.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,334,725.00</b>	<b>44,334,725.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,213,700.00	50,478,700.00	-3,735,000.00	93.11
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>54,213,700.00</b>	<b>50,478,700.00</b>	<b>-3,735,000.00</b>	<b>93.11</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,653,700.00	31,918,700.00	-3,735,000.00	89.52
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,560,000.00	18,560,000.00	0.00	100.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00		0.00	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,408,421,300.00</b>	<b>4,913,638,998.00</b>	<b>1,505,217,698.00</b>	<b>144.16</b>
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,408,421,300.00</b>	<b>3,460,986,000.00</b>	<b>52,564,700.00</b>	<b>101.54</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,408,421,300.00</b>	<b>3,460,986,000.00</b>	<b>52,564,700.00</b>	<b>101.54</b>
Улсын төсвөөс санхүүжих	3,408,421,300.00	3,460,986,000.00	52,564,700.00	101.54
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,449,560,000.00</b>	<b>1,452,652,998.00</b>	<b>3,092,998.00</b>	<b>100.21</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,319,560,000.00	1,322,652,998.00	3,092,998.00	100.23
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000,000.00	130,000,000.00	0.00	100.00



## АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төсвийн гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30,299,222.00</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>30,299,222.00</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,596,500.00
Урамшуулал	5,596,500.00
<b>Нормативт зардал</b>	<b>15,590,000.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,590,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,092,722.00</b>
Урсгал засвар	2,092,722.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,020,000.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	7,020,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>30,779,226.00</b>
<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>30,779,226.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,929,704.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,797,522.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,052,000.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**